

Соёл хоорондын харилцааг когнитив байр сууринаас авч үзэх нь

Доржпүрэвийн Чулуунгэрэл, доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс, chuluungereld@mas.ac.mn;
<https://orcid.org/0000-0002-7808-3673>

Article history

Received : 2024-08-31

Accepted : 2024-09-28

Published : 2024-12-20

Түлхүүр үгс

когнитив ухаан,
когнитив хүн
судлал,
соёл, сэтгэлгээ,
ойлгохуй

Keywords

cognitive science,
cognitive
anthropology,
culture, mentality,
perception

Хураангуй: Когнитив антропологи нь түүхэн соёлын үзэгдэл бөгөөд хөгжлийнхөө явцад мэдлэг болж, дамжиж ирсэн сургаалын цогц юм. Орчин үед хэл шинжлэл, сэтгэл судлал, хүн судлалын шинжлэх ухаан төдийгүй олон шинжлэх ухаанууд когнитив чанарыг хадгалж, танин мэдэхүйн үүргийг гүйцэтгэж байна. Когнитив хүн судлал нь соёлын ухамсар, танин мэдэхүйн судалгаан дээр тулгуурлан хөгжсөн юм.

Examining intercultural communication from a cognitive perspectives

Chuluungerel Dorjpurev (Ph.D)

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia, chuluungereld@mas.ac.mn;
<https://orcid.org/0000-0002-7808-3673>

© The Author(s), 2024



Abstract: Cognitive anthropology is a set of historical cultural phenomena and teachings that are known in the process. In modern times, not only psychology, linguistics, and anthropology, but also many other disciplines maintain cognitive quality and perform cognitive functions. Cognitive anthropology is based on cultural consciousness and cognitive analysis.

I. Оршил

Когнитив хүн судлалын ойлголт: Когнитив сэтгэл судлал, хэл шинжлэлтэй зэрэгцэн когнитив хүн судлалын судалгаа хөгжиж байсан. Энэхүү чиглэлийн гол төлөөлөгчид нь Ж.Лакофф, М.Жонсон, Р.Жэкендорф, Р.Лэнекер, Л.Талми, Ч.Филлмор, Ж.Фоконье нар юм. Тэдний судалгааны чиглэл нь сэтгэлгээ ба хэлний харилцааны асуудал, мэдлэгийн дамжуулалт, хадгалалт, бүтээлч чанар, шинжлэх ухааны хөгжилд нөлөөлөх асуудал зэргийг судалж иржээ. Үүнийг соёлын ухамсар, танин мэдэхүйн судалгаа талаас нь У.Гуденаф, Ф.Лаунсбери, Х.Конклин, Р.Д.Андрад, М.Коул нар авч үзсэн байна. Когнитив хүн судлаачид *«Соёлыг [мэдлэгийн систем], [концепцийн систем], [утгын нийтлэг систем] гэсэн призмээр»* судалж, тайлбарлах оролдлого хийжээ.

Соёл нь тэдний үзснээр *[Сэтгэлгээний ухаарал]* гэж ойлгогдоно. Соёл бол нийгмийн гишүүн бүрт оршин байх, ойлгох, тайлбарлах, тодорхойлох, ухаарах боломжийг олгож байдаг үзэгдэл юм. *[Соёлын үзэл баримтлал нь танин мэдэхүй ба бэлгэдэл бөгөөд харин зан төлөв, зуршил биш юм. Соёл нь мэдээллийг агуулж байгаа систем бөгөөд ДНК эсийн адил билээ]* (Roy.G 1984) хэмээн Р.Д.Андрад үзжээ.

II. Судалгааны арга зүй

Тус өгүүлэлдээ түүхэн ба логик шинжилгээ, харьцуулсан арга зүй, танин мэдэхүйн судалгааны ерөнхий аргыг ашигласан.

III. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

Соёлын танин мэдэх үйл явц нь *сэтгэлгээ (менталитет) ба ойлгохуй (восприятия)* гэсэн ухагдахуунаар илүү тайлбарлагдах боломжтой гэдгийг когнитив ухаанд авч үздэг. *Ойлгохуй* гэдэг нь сэтгэцийн (*когниц*) идэвхтэй үйлдэл бөгөөд хүрээлэн буй орчны үзэгдэл юмсын талаарх хүний ухамсарт байгаа бүхэллэг үйл явц юм.

Ойлгохуй нь цочроогчийн шууд үйлдлээр организмын дотоод орчинд үйлчилдэг. Объектүүдийн харилцан хамаарал, үйл ажиллагаа, бүтцээс ойлгохуй нь бүрдэнэ. Ж.Брунер [ойлгохуйг категорийн шинжтэй] гэдгийг баталж, хэд хэдэн ангилалд хамаарах утга санааг илэрхийлж байгаа зүйлийг ойлгохуй гэнэ (Брунер Ж. 1977) гэж үзсэн. Жишээ нь, тухайн объектуудын голлох шинж чанарыг ялгаж харснаар бид категорийн сонголт хийнэ. Бидний ялгасан шинж чанар ойлгохуйн үйл явцтай холбогдон, ойлгохуйн тухай ерөнхий ба явцуу ухагдахуунуудыг бий болгоно. Ойлгохуйн түвшинд хэрэглэгдэж байгаа категориуд амархан өөрчлөгддөггүй, ойлгохуй энэ шинжээрээ

сэтгэлгээнээс ялгагддаг (Брунер Ж. 1977). Ойлгохуйн өөр нэг гол шинж нь бодит байдлыг ямар нэг аргаар хуулбарлан буулгах чадвартайд оршино. Хүний ойлгох чадвар гэдэг бол ажиглагдаж байгаа объект ба тухайн үйл явдлын хоорондхи харилцааны шинж байдаг юм. Хүний энэ чадвар бодит ертөнц ба таамаглал, урьдчилан зөгнөсөн нөхцөл байдлын дунд бас бүрдэнэ. Ойлгохуйн үндэс нь кодчлолын тодорхой систем бөгөөд зайлшгүй тохиолдолд хүрч болохгүй мэдээллүүдийг сэргээх боломж олгоно. Ж.Брунерын үзсэнээр ойлгохуйн зөв ба тодорхой байдал нь ирж буй мэдээллийн сонгосон кодтойгоо таарч байгаа эсэхээс ихээхэн хамаарна. Ер нь *ойлгохуй* гэдэг бол бие организмд логик дүгнэлтийг өгөх замаар өрнөж буй үйл явц бөгөөд дохио бүрд ойлгохуй нь хүртээмжтэй байж чаддаггүй.

Ойлгохуйн перцептив шинж чанар нь тухайн үйлдлийн субъектив үнэлэмжийн магадлал ба субъектын сонирхол, хэрэгцээнээс хамааралтай. Тухайн объектын ойлгогдохгүй байгаа шинж чанар, бусад зүйлийг тааварлах боломж, саад хязгаарыг туулах бололцоо нь ухагдахуунуудын тусламжтайгаар ойлгохуйн үйл явцад өрнөнө. Энэ үед хүртэгдэж чадахгүй байгаа ойлгохуйн үр дүн гажуудах явдал гардаг. Үүнийг бид Ф.Бартлетын хэлсэн жишээнээс харъя.

Лондонд нүүж ирсэн Африк хүмүүс ба Лондоны замын хөдөлгөөнийг зохицуулж буй цагдаа нарын хооронд онцгой найрсаг харилцаа бий болсон байна. Үүний учир нь, тэд үйлдлийн ойлгохуйг өөр өөрөөр хүлээж авсанд оршино. Цагдаа нар гараа өргөх үйлдэл хийснээр хөдөлгөөнийг зогсоох, зохицуулах дохиолол өгч байсан. Харин Африкчуудын хувьд гараа өргөх нь найрсаг сэтгэгдлийн илэрхийлэл бүхий дохио юм. Эндээс харахад, энэ жишээ нь, үйлдлийг ойлгохуйн түвшинд ялгаснаар шинж чанарыг тодорхойлох, хоорондын холбоосыг тогтоох бололцоо олгогддог нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, үйлдэл бүр дохиогоор дамжиж буй ойлгохуйг зөв таньж мэдэх нь чухал болно.

Аливаа зүйлийг ойлгох нь хэрэгцээ болон үнэлэмж, үнэт зүйлээс ихээхэн хамааралтай. Ер нь үнэт зүйл ба хэрэгцээ шаардлага нь ойлгохуйг бүрдүүлж, зохион байгуулж буй гол хүчин зүйл нь болдог. Ойлгохуй нь өмнөх үеийн туршлагаар нөхцөлдөж баяжигдан, идэвхтэй болж байдаг үйл явц юм. Тухайн объектын үнэлэмж нь ямар байгаа, энэ объект хүний зан төлөвийг хэрхэн утга төгөлдөр болгож байгаа зэргээс шалтгаалан, ямар үнэ цэнтэй ойлголт бүхий зүйл вэ гэдэг нь тодорхойлогдоно. Ойлгохуй нь идэвхгүй, бясалгагч шинж бүхий төсөөлөл ердөө ч биш. Тиймээс

ойлгохуй нь шинэ ертөнцийг бүтээх сэтгэлгээний тусгалын онцгой хэлбэр билээ. Ямар ч зүйлийн хүртээмжтэй шинжийг соёл-түүхийн хандлагаас нь харвал, онол практикийн харилцан хамаарлаар тайлбарлагддаг. Хүн төрөлхтөн түүхэндээ хийсэн, бүтээсэн зүйлийн тухай үр дүн, практик ач холбогдол нь хүртээмжит шинжийг **(перцепци)** тодорхойлж байдаг. М.Вартофский хүртээмжийн тухай авч үзэхдээ, цэвэр биологийн ба сэтгэл судлалын онолоос татгалзаж, [хүртээмж гэдэг зүйл хүний мэдрэхүйн системийн биологийн хөгжлийн төгсгөл үед үүссэн] (Wartofsky M. 1973) гэж тодорхойлжээ.

Хүртээмж гэдэг ойлголт нь дотоод үйл ажиллагаа төдийгүй гадаад үйлдлийн хэлбэр юм. Мөн организмын хэрэгцээ, орчноор ч хүртээмж бас тодорхойлогдоно. Хүний практик үйл ажиллагааны бүх хэлбэрт хүртээмжит шинж агуулагдаж байдаг бөгөөд үйл ажиллагааны түүхэн хэлбэрүүд өөрчлөгдөхийн хэрээр ойлголтын агуулга ба хүртээмжит шинж бас өөрчлөгдсөөр иржээ.

Түүнээс гадна М.Вартофский үзэл баримтлалаар перцепцийг тархинд болон ухамсарт явагдаж байгаа дотоод үйл явц гэж үзэх нь алдаатай оролдлого юм. Ойлгохуйн тухай онолуудаас М.Вартофскийн онол нь дараах

хоёр зүйл дээр тулгуурлаж байгаагаараа ялгаатай. Үүнд,

1. Перцепцийн объектээс перцепцээсээ хамааралгүй авч үзэх, (хэдийгээр тэд перцептуаль идэвхтэй үйлдлийг дамжиж нөхцөлддөг байсан ч)
2. Объектуудын элементүүд нь бидэнд тэдний сэтгэлгээний репрезентациар дамжиж, танин мэдэгддэг. Нэг үгээр хэлэхэд, перцепцийн объект нь бодит байдлын объектыг агуулах бөгөөд энэ нь орон зай, цаг хугацааны материаллаг объект ба бидний ойлгож авч байгаа үйл явц юм.

Перцепци гэдэг бол **организмын интерактив дасан зохицол бөгөөд организмуудын хэрэгцээ, орчноор тодорхойлогдож байдаг** (Wartofsky M. 1973). Ингэхлээр хүртээмжит шинжийг үйл ажиллагааны соёл гэж бас ойлгож болох юм. Соёлын антропологич Ф.Бокк ч гэсэн үзэхдээ: [Соёл нь танин мэдэхүй, ойлгохуйн үйл явц бүхэнд агуулагдаж байдаг] (Wartofsky M. 1973) гэсэн юм. Гэвч янз бүрийн соёлын туршлагаас шалтгаалан тухайн ойлголт нь мөн өөр өөрөөр илэрхийлэгдэнэ. Энэ тухай Мацумото «Сэтгэл судлал ба соёл» (Мацумото Д. 2003) хэмээх бүтээлдээ хэрхэн өгүүлснийг авч үзье. Мацумото Австралид абориген нарын хүүхдүүдэд хичээл зааж байжээ.

Тэрээр нэгэн удаагийн хичээл дээрээ {хэн надад хүрсэн бэ} гэх нэртэй тоглоомыг тоглуулахаар шийдэж, тоглоомоо ийн тайлбарлажээ. Бүх хүүхдүүд босож, тойрог болж зогсоно, ингэхдээ хүүхдүүд нүдээ алчуураар боосон байна, харин тойргийн дотор төв хэсэгт нэг хүүхэд зогсож удирдана. Дараа нь тойргийн эгнээнээс нэг нь гарч, удирдаж байгаа хүн рүүгээ чимээгүй дөхөж очин, түүнд хүрээд, байрандаа буцаж очно. Харин тойргийн дотор байгаа хүн алчуураа аваад, хэн түүнд дөхөж ирж, гар хүрснийг олох ёстой ажээ. Гэтэл энэ тоглоом аборигени хүүхдүүдэд ямар ч баяр хөөр хөгжил авчраагүй. Багш бодохдоо хүүхдүүд эрх дураараа бас мунхаг байна гэж ойлгожээ. Өөр нэг сонирхолтой зүйл нь багшийн нэр хүнд сурагчдын дунд унаж, хүүхдүүд багшийгаа мунхаг гэж тооцох болсон байна. Учир нь багшийн төлөвлөсөн тоглоом хүүхдүүдийн хувьд маш амархан бөгөөд шийдвэрлэхэд сонирхолгүй зүйл болсонтой холбоотой ажээ. Учир нь, аборигени хүүхдүүд бүр багаасаа хүнийг алхаа ба хөлөөр нь таних аргад суралцдаг байжээ. Ингээд хүүхдүүд багшийгаа ийм энгийн зүйлийг мэдэхгүй байна, магадгүй хангалттай мэдлэгтэй биш юм байна гэж дүгнэж, анхаарал хүндлэл нь суларчээ. Өөрөөр хэлбэл, тухайн тоглоом нь хүртээмжтэй байх ойлголтыг

эхэлж судлах ёстойг харуулж буйн тод жишээ.

Соёл, хүн судлал, сэтгэл судлалын хувьд хүртээмжтэй байх нөхцөл нь соёлын нөлөөллийн асуудалтай ихээхэн холбоотой. Үүнд, хамгийн түрүүнд тухайн соёлын харааны ойлгохуй чухал байр суурь эзэлдэг. Ялангуяа харж мэдэрснээр ямар ойлголт төрөн гарч байгаа сэдвээр судлаачид ихэд сонирхон туршилт судалгаа хийсэн байдаг. Судлаачид нүдний оптик тусгал ба тусгалаар дамжин гарч буй ойлголт нь хаана хүрч байгааг судлахад голлон анхаарсан. Жишээ нь, судлаач Мюллер Лайер нум сумны уртыг олох туршилт хийж, аль нь илүү урт вэ гэдгийг тодорхойлохыг зорьсон. Туршилтын дүнд нум, сумны урт нь адилхан, гэхдээ босоо ба хэвтээ хууралт гэсэн ойлгохуй чухал юм байна. Дотогшоо чиглүүлсэн сумны хэсэг, гадагшаа чиглүүлснээс урт харагдах, босоо шугам нь ойрхон байхад түүний цаана оршиж байгаа шугам нь илүү урт харагдах ойлгохуй байна. Гэтэл үнэн хэрэгтээ нум сумны урт адилхан.

Мюллер Лайерын босоо хэвтээ хууралтын туршлагыг 1905 онд Английн антропологич У.Риверс соёл хоорондын харилцаан дээр туршиж үзсэн. Тэрээр Англи, Эртний Энэтхэг, Шинэ Гвинейн нутгийн иргэдээс бүрдсэн бүлгүүдийг сонгон авч, эдгээр хүмүүсийн ямар шинж давамгайлах болон дагалдах

онцлогтой байгааг харуулжээ. (Rivers W.H.R 1905, 332) Зарим судлаачид хүй нэгдлийн үеийн хүмүүсийн оюун ухааны хөгжлийн дутмаг байдлыг тэдний сэрлийн хөгжлийн түвшин нөхөж байна гэж үзэж байсан. У.Риверс энэхүү нөхцөлтэй санал нэгдэж, байгалийн үзэгдлээс ангид юм ер байхгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн. Сэрэл ба оюун ухаан нь салангид зүйл биш харин сэрлийн суурь нөхцөлд хэт их энерги зарцуулбал мэдээж, дээд мэдрэл, оюун ухааны бүтцэд ч ачаалал ирнэ гэжээ (Коул М. 1997, 65).

У.Риверс, У.Мак Дугалл, К.С.Майерс зэрэг судлаачдын хамтаар **харааны ойлгохуйг сэтгэл судлалын үйл явц мөн** хэмээн үзэж, судалгаа хийсэн. Тэдний судалгаа харааны хурц байдал, өнгө ойлгох чадвар, цаг хугацааг харах онцлог ба сонсох, амтлах сэрэлд хариу үйлдэл өгөх хугацаа, ой тогтоолт зэргийг судлахад чиглэсэн. Нутгийн уугуул иргэд ба Европчууд цэцгийн өнгийг хэрхэн ялгаж байгааг туршихад нутгийн уугуул иргэд нь цэнхэр, ногоон өнгийг хооронд нь хольж, төдийлөн сайн ялгахгүй байгаа нь ажиглагдсан. Гэтэл хоорондоо маш ойрхон зайд байгаа тэнгисийн хоолойг европ хүмүүс нь ялгаж харж чадахгүй байхад нутгийн иргэд маш амжилттай ялгаж байсан. Өөр нэгэн сонирхолтой үр дүн нь Соломоны болон Торреса арлын иргэдийн харааны хүртэхүй, ойлгохуйн чадвар нь үнэхээр

гайхалтай байсан явдал юм (Haddon A.C. 1996, 106). Тэд нутгийн иргэд нь далайгаас алсад байгаа зүйлсийг олж харах, илрүүлэх чадвараараа Европчуудаас хол тасархай илүү байсан. Харин Шинэ Ирландын тариачид навч, модны завсар нуугдаж байгаа зүйлийг гайхамшигтайгаар илрүүлж чаддаг авьяастай байсан. Мюллер Лайерын хууралтын судалгаанд Англичууд тухайн уртыг ялгаатай гэж үзсэн бол Шинэ Гвинейн иргэд бараг ялгаагүй гэв. Харин босоо хэвтээ хууралтад Шинэ Гвинейн иргэд илүү автагдаж, Европын судлаачдыг ихэд гайхшируулсан. Судлаачид нийгэм-соёлын хоцрогдонгуй хөгжлийн төлөөлөгчид нь гажуудсан ойлголтыг амархан хүлээж авч байгаагаас харахад, аливаа зүйлийг ойлгох нь соёл орчны нөлөөлөлтэй шууд холбогдож байгаа нь ажиглагдсан. Иймд Риверс **ойлгохуйн үйл явцад соёлын хүчин зүйл нөлөөтэй** гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлжээ. Янз бүрийн соёлын үзэгдэлд төөрөгдөл ойлголт буй болдог тухай У.Риверс, Мюллер Лайерын судалгааг цааш нь М.Сегалл, Д.Кэмпбелл, М.Херцковиц нар үргэлжлүүлж, ойлголтын асуудлаар эсрэг хандлагуудыг дэвшүүлсэн. Тэд судалгааны ажлынхаа үр дүнгээр «Харааны ойлгохуйд үзүүлэх соёлын нөлөө» гэх бүтээлийг туурвисан юм (Hersrowits M.N. 1968, 106). Гагцхүү

М.Херцковиц харааны ойлгохуй соёлын хүчин зүйл нөлөөлнө гэдгийг баталсан бол Д.Кэмпбелл эсэргүүцжээ. Хүн судлаачид болон сэтгэл судлаачид Д.Кэмпбелл, М.Херцковиц нарын таамаглалыг шалгахгаар шийдэж, [мужааны ертөнц], [ирээдүйтэй уран зураг] хэмээн метафорчлон нэрлэсэн.

[Мужааны ертөнц]-ийн таамаглал ёсоор Баруун Европын хүмүүс нь тэгш өнцөгт хэлбэртэй дүрслэлээр хүрээлэгдсэн байдаг учир Мюллер Лайерын хууралтад илүү автагджээ. Харин уламжлалт соёлыг тээгчид нь дугуй, тойрог болон геометрийн зөв биш дүрсүүдээр хүрээлэгдсэн учир Мюллер Лайерын хууралтад төдийлөн автагдаагүй байна. Европын хүмүүсийн хувьд зөв шулуун хэлбэртэй эд зүйлс, юмсыг шууд л тэгш өнцөгт хэмээн тайлбарлаж даджээ. Түүгээр ч зогсохгүй бүр тэгш өнцөгт биш зүйлүүд хүртэл тэгш өнцөгт мэтээр харагддаг болсон гэнэ. Тиймээс Мюллер Лайерын илбээр тэгш өнцөгт дүрсийг хүмүүсээс янз бүрийн зайнд ба доод шугаманд байрлуулсан ч [урт] хэмээн ойлгож байна. [Ирээдүйн уран зураг] хэмээх таамаглал нь хэвтээ босоо хууралтад илүү тулгуурлаж байгаа ба босоо шугамыг бага хардаг, илүү алсад хараагаа чиглүүлдэг хүмүүст сул илэрч байгаа нь харагдана. Нөгөө талаас төгсгөлгүй тал газар

амьдарч байгаа хүмүүсийн хувьд хэвтээ шугамаар дүрслэгдсэн зүйлс нь босоо мэтээр харагдаж байна. Эдгээр таамаглалуудыг батлахын хувьд М.Сегалл өөрийн хүмүүсийн хамтаар харьцуулсан туршилт хийсэн. Тэдний туршилтад аж үйлдвэржсэн гурван орон, хөдөө аж ахуйн арван дөрвөн улс хамрагдсан байна. Туршилтын үр дүнд аж үйлдвэржсэн орноос сонгосон бүлгүүдэд нь Мюллер Лайерын илбэ илүү ач холбогдол өгсөн. Харин хөдөө аж ахуйн орнуудын иргэд нь хэвтээ босоо илбэд автаагүй.

Харааны чадвар ойлгохуйн тухай У.Хадсон [бант] хэмээх овгийн жишээн дээр судалж, сонирхолтой баримтыг дэлгэсэн. Бант овгийнхон хараагаараа ямарваа юмны зайг тодорхойлохдоо харьцуулсан ямар ч хэмжээсийг ашигладаггүй байсан байна (Hudson W. 1960, 52). Тэдний өмнө нэг уран зураг тавиад, тайлбарлахыг хүссэн. Зурагт үйлдвэрийн газар, гараа хөдөлгөн ярьж байгаа илтгэгч дүрслэгдсэн байсан. Гэтэл бантын хүмүүс тус зургийг хоёр өөр байдлаар тайлбарласан. Европт очиж үзээгүй бас боловсрол эзэмшээгүй бантууд зурган дээр байгаа илтгэгчийг үйлдвэрийн жижигхэн хоолойд гараа дулаацуулж байгаа хүн гэж ойлгосон. Харин Европчуудтай уулзаж үзсэн, Европын сургуулиудад боловсрол эзэмшиж, соёлоос нь суралцсан бантууд зургийг яг европ хүн

шиг тайлбарласан байна. Ингээд У.Хадсон хараатай холбоотой ойлголт нь соёлын хүчин зүйлтэй холбоотой юм байна гэсэн дүгнэлт хийжээ. Өөрөөр хэлбэл, боловсролгүй бантууд нь Европын соёлыг чухалчилсан ажээ.

Судлаач В.Г.Богораз чукчануудын харааны чадвар, ойлгохуйн судалгааг (Bogoraz W.G. 1904-1909, 124) чукча иргэдийн дунд явуулж, мөн л сонирхолтой дүгнэлтэд хүрсэн. Чукча нар өнгөний нэршлийн тухай тун бага мэдлэгтэй байгааг В.Богораз ажиглаж, тэднээр өнгө ялгуулж сургах ажлыг ихэд хөдөлмөр гаргаж хийсэн. Гэхдээ чукча нар цаа буганы арьсны хээ ба өнгийг гайхамшигтайгаар ялгаж чадаж байсан. Тэрхүү арьс нь В.Богоразын хувьд яг нэг зүйл мэт харагдаж байсан бөгөөд В.Богораз цаа бугачид ямар шалгуураар арьсны өнгө, хээг тогтоож чадаад байгааг ойлгоогүй. Харин В.Богораз чукча нарын амьдралд харааны чадвар ойлголт соёлоос гадна [үнэр] хүчтэй үүрэг гүйцэтгэж байдаг гэдгийг илрүүлжээ. Тэд мэндлэх болон эд зүйлсийг тодорхойлохдоо үнэрлэх чадвараа ашигладаг, өөрөөр хэлбэл, аюултай эд зүйлс нь муухай үнэртэй байдаг гэх тодорхой үзэл баримтлалтай болохыг олж мэдсэн. Богораз чукча гэр бүлд нэгэн хайрцагтай зүйлийг өгөхөд гэрийн эзэгтэй тэр хайрцагас онцгой үнэр гарч буйг мэдрээд, бараг ухаан алдсан. Харин Богораз тэр

хайрцагас ямар ч үнэр гарахгүй байна гэж тайлбарласан боловч гэрийн эзэгтэй хорон муухай үнэр хүчтэй гарч байна гэж хэлсэн.

Соёлын хүн судлалын хүрээнд өнгийг ялгах, ойлгох судалгааны түүх нэлээд сонирхол татдаг. Энэ онол Э.Сепир, Б.Л.Уорф нарын хэл шинжлэлийн онол хөгжихөд ч томоохон нөлөө үзүүлжээ. Тэд үзэхдээ *хүн ертөнцийг танин мэдэхдээ өөрийнхөө хэлний аргыг ашигладаг* гэсэн юм. Соёл хоорондын судалгааны явцад орчин үеийн эскимосчуудын хэлэнд [цас] гэх ойлголтыг илэрхийлсэн ойролцоогоор 20 янзын үг байгааг тогтоосон. Англи хэлэнд нэг, ацтекуудын хэлэнд нэг үүнээс эскимосчуудын хувьд цасыг ойлгож байгаа нь ихэд онцгой ялгавартай гэдэг нь харагдаж байна. Гэвч энэ хандлага нь Америкийн соёлын хүн судлаач Б.Берлин, П.Кэй нарын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан. Тэд өөрсдийн анхаарлыг өнгөний хязгаарт биш, өнгөний төв дэр тодорхойлон төвлөрүүлэхийг оролдсон, ингээд тэд туршилтаа 20 хэлээр ярьж байгаа бүлгийн дунд хийсэн байна. Туршилтад оролцогчдоос өнгө гэдэг үгийг тодорхойлж байгаа хамгийн суурь тодорхойлолтыг өөрийн хэл дээр ангилж хэлэхийг хүсэн. Цаашид тэд 329 загварыг сонгож авах хэрэгтэй болсон ба эдгээр нь:

1. Сонгосон өнгөний ухагдахуун бүхэнд тохирч байх ёстой

2. Илүү түгээмэл байх ёстой гэж үзжээ.

Гэвч янз бүрийн хэлэнд өнгөний ухагдахууныг

илэрхийлсэн хязгаарууд тохироогүй, харин хамгийн сайн гэж байгаа сонголтоор өнгөний зарим нэг нь ижилхэн болж гарсан. Дараах хүснэгтээр ерөнхий 7 өнгө хэдэн хэлэнд тохирч буй эсэхийг харуулав.

Өнгө	Хэдэн хэлэнд адил болох
Хар – цагаан - улаан	20 хэлэнд ижил байсан
Ногоон	19 хэлэнд ижил байсан
Шар	18 хэлэнд ижил байсан
Цэнхэр	16 хэлэнд ижил байсан
Бор - үзмэн ягаан	15 хэлэнд ижил байсан
Саарал	14 хэлэнд ижил байсан
Ягаан - шар ягаан	11 хэлэнд ижил байсан

Б.Берлин, П.Кэй нар үндсэн 11 өнгийг ялгаж, эдгээр өнгөнүүдийг ямар ч хэлний түүхэнд кодчилж болно гэж үзсэн байна (Кай Р., Берлин В., 1969, 16). Тэдний үзсэнээр, хар болон цагаан өнгийг нэрлэсэн нэр хамгийн түрүүнд үүссэн. Харин тухайн хэл 3 янзын нэр томъёог агуулж байгаа бол түүний дотор нь улаан өнгөний нэр заавал байгаа, хэрвээ хэл 4 янзын нэр томъёог илэрхийлж байгаа бол ногоон, шар өнгө 5 байвал түүн дотор шар, ногоон өнгө орно. 6 бол цэнхэр өнгө, 7 бол бор өнгө, 8 бол түүнд үзмэн ягаан, ягаан,

саарал өнгө байх нь тодорхой боллоо гэж үзсэн байна. Ер нь универсаль өнгөний тайлбарлалын тухай сонирхолтой онолыг А.Вежбицкая гаргаж байсан бөгөөд түүний дэвшүүлсэн өнгөний үзэл баримтлал нь хүний туршлагын универсаль элементтэй холбогдоно. Эдгээр нь өдөр шөнө, нар, гал, ургамал, тэнгэр газар гэх мэтээр ч тодорхойлогдож болох юм. Нэг үгээр хэлбэл, доорх зурагт өгүүлснээр нийлүүлж авч үзэх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрчээ (Вежбицкая А. 1997, 283).

Өнгө	Элемент
Хар – цагаан	Өдөр - шөнө
Улаан	Гал
Ногоон	Ургамал
Шар	Нар
Цэнхэр	Тэнгэр
Бор	Газар

Байгаль, хүрээлэн байгаа орчныг сэрлийн эрхтний болон

түүнийг дагалдсан ойлголтоор танин мэдсэний эцэст

эргэцүүлэл, харьцуулалт, оюун дүгнэлт хийх сэтгэлгээний үйл явц эхэлдэг. Нэг үгээр хэлбэл, мэдрэмж (сенсор), хүртээмжийн замаар олж авсан мэдээллийн тусламжтайгаар сэтгэлгээ нь сэрлийн хязгаараас давж, орчны танин мэдэхүйн асуудал руу орно. Сэтгэлгээ нь ахуйн янз бүрийн харилцаа холбоонд репрезентаци хийхийг уриалдаг юм. Гэхдээ бид сэтгэлгээнд байгаа практик болон онолын шинжийг ялгах хэрэгтэй.

Онолын сэтгэлгээ нь хийсвэрлэлийн тусламжтайгаар туршлагын үйлдлийг ойлголтын дүр зураг болгодог. Энэ дүр нь сэрлийн эрхтний нөлөөгөөр мэдээлэгдэж, ой тогтоолтод урт хугацаанд оршиж, дүрслэлээр бүтээгддэг юм.

Практик сэтгэлгээ бол үзэгдэж буй дүр, харагдаж буй үйл ажиллагаа юм. Хүн бодит байдалтай харьцсанаар бүтээлч үйл ажиллагаатай холбогдоно. Онолын сэтгэлгээний үр дүн нь практик үйлдэл болж болно. Мөн практик сэтгэлгээний үр дүнд онолын сэтгэлгээний ерөнхий зүй

тогтол нь илэрч болно. Оросын эрдэмтэн Э.В.Ильенковын тэмдэглэсэнээр: *«Сэтгэлгээ гэдэг бол дурын биес, эд юмстай харьцах чадвар бөгөөд сэтгэлгээний орчин ба үйл ажиллагаанаас танин мэдэхүйн үр дүн гарах үйлдэл»* ажээ (Ильенков Э.В. 1991, 273).

IV. Дүгнэлт

Когнитив ухааны үзэл баримтлалуудын нэг нь сэтгэлгээний үйл явцад соёлын шинж чанарыг зайлшгүйгээр харгалзан үзэх ёстой гэсэн үзэл баримтлал орж байдаг. Ж.Брунер энэ тухай бичихдээ: *«Хүмүүст соёлын хүчин зүйлээр олон юм өгөгдсөн. Тэдгээрээс хамгийн чухал нь сэтгэлгээ бөгөөд сэтгэлгээний бүтцэд соёл оролцоно»* гэсэн юм (Брунер Ж. 1977). Дээрх бүхнээс авч үзэхэд, соёлын үндэс болж байгаа сэтгэлгээ нь янз бүр гэдгийг судлаачид эсэргүүцээгүй бөгөөд хувьсан өөрчлөгдөж байгаа соёлын үүргийг тодорхойлоход зайлшгүй хэрэгтэй болно.

Ашигласан материал

- Roy.G, D'Andrade. 1984. "Cultural meaning systems" In *Cultural theory. Essays on mind Self and emotion*, by Richard A.Shweder. NY: Cambridge University press.
- Брунер Ж. 1977. *Психология познания. За пределами непосредственной информации*. Москва: "Прогресс"
- Wartofsky M. 1973. *Models: Representation and Scientific Understanding*. Vol. 48. Boston: Boston Studies in the Philosophy of Science .
- Мацумото Д. 2003. *Психология и культура*. Санкт-Петербург.
- Rivers W.H.R. 1905. "Observations on the senses of the Todas" 332.
- Коул М. 1997. "Культурно-историческая психология наука будущего" 65. Москва.
- Haddon A.C. 1996. "The influence of culture on perception" 106.
- Hersrowits M.N., Segall D.T.,. 1968. "The influence of culture on perception" *Massachusetts Institute of Technology* 106.
- Hudson W. 1960. "Pictorial depth perception in sub-cultural groups in Africa" *Journal of Social psychology* 52.
- Bogoraz W.G. 1904-1909. "The Chukchee" *Part material culture* 124.
- Kay P., Berlin B. 1969. *Basic colour terms*. CA: California press.
- Вежбицкая А. 1997. *Язык Культура Познание*. Москва.
- Ильенков Э.В. 1991. "Философия и культура" 273. Москва.

